

СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ИЛ ТОД БАЙДАЛ БА ХЯНАЛТ

TRANSPARENCY AND CONTROL OF ELECTION EXPENCES

Удирдагч: Я.Батгэрэл. ДХИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн Иргэний шийдвэр гүйцэтгэлийн тэнхимийн профессор, доктор (Ph.D), хурандаа

Ya.Batgerel. Professor, Department of Civil Decision Execution, the School of Court Decision Execution, University of Internal Affairs, Master in law, Doctor (Ph.D), Colonel

Г.Хулан. ДХИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн 542-р дамжааны сонсогч

G.Khulan. The School of Court Decision Execution, University of Internal Affairs, a cadet of 542 course

Товч агуулга: Ардчилсан сонгуулийн шударга, ил тод, тэгш, өрсөлдөөнтэй байдлыг хангах үндсэн нөхцөл нь сонгуулийн санхүүжилт, тэр дундаа нам, эвсэл болон нэр дэвшигчдэд олгогдож буй хандивын ёс зүйн болон хуульд нийцсэн байдал юм. Монгол Улсад сүүлийн жилүүдэд сонгуулийн зардал нэмэгдэж, түүнийг дагасан хандивын далд нөлөө, ашиг сонирхлын зөрчил, улс төр болон бизнесийн харилцан хамаарал хурцдаж байгаа нь ардчиллын чанарт сөргөөр нөлөөлөх эрсдэлийг бий болгож байна.

Монгол Улсад сүүлийн жилүүдэд сонгуулийн зардал тогтмол өсөх хандлага ажиглагдаж, үүнийг дагасан далд санхүүжилт, хууль бус хандив, ашиг сонирхлын зөрчил нь ардчилалд бодитой заналхийлэл учруулж байгаа юм. Сонгуулийн хэт өндөр зардал нь нэр дэвшигчдийг тодорхой санхүүжүүлэгчдийн нөлөөнд орох, улмаар төрийн бодлого, шийдвэр нь олон нийтийн ашиг сонирхлоос илүүтэйгээр хувийн болон бүлгийн ашиг сонирхолд үйлчлэх нөхцөлийг бүрдүүлж болзошгүй. Энэ нь төлөөллийн ардчиллын суурь зарчим болох иргэдийн улс төрийн тэгш оролцоог алдагдуулж, сонгуулийн үр дүнд итгэх олон нийтийн итгэлийг сулруулах сөрөг үр дагавартай.

Энэхүү илтгэлийн хүрээнд Монгол Улсын Их хурлын сонгуульд оролцож буй нэр дэвшигчид, улс төрийн намуудын сонгуулийн компанит ажлын санхүүжилтийг зохицуулах эрх зүйн орчин, түүний хэрэгжилт, сонгуулийн зардалтай холбоотой ёс зүйн зөрчил, түүнд тавьж буй хяналтын тогтолцоо, өнөөгийн нөхцөл байдлыг судлан сайжруулах арга зам, шийдлүүдийг дэвшүүлэн дүгнэлт, санал боловсрууллаа.

Abstract: The main condition for ensuring fair, transparent, equal and competitive democratic elections is the ethical and legal compliance of election financing, including donations to parties, coalitions and candidates. In recent years, the increase in election costs in Mongolia, the hidden effects of donations, conflicts of interest and the intensification of political-business relationships that accompany it, create a risk of negatively affecting the quality of democracy.

In Mongolia, election costs have been steadily increasing in recent years, and the resulting hidden financing, illegal donations, and conflicts of interest pose a real threat to democracy. Excessive election costs can create conditions where candidates are influenced by certain funders, and as a result, state policies and decisions may serve personal and group interests rather than the public interest. This has the negative consequences of undermining the equal political participation of citizens, which is a

fundamental principle of representative democracy, and weakening public confidence in election results.

Within the scope of this report, we have examined the legal framework regulating the campaign financing of candidates and political parties participating in the Mongolian State Great Khural elections, its implementation, ethical violations related to election expenses, the control system imposed on them, and the current situation, and proposed ways and solutions to improve them, and developed conclusions and suggestions.

Түлхүүр үг: Ардчилсан сонгууль, ил тод байдал, ёс зүй, хариуцлага, ашиг сонирхлын зөрчил, хандив, хяналт, сонгуулийн зардал

Key words: Democratic elections, transparency, ethics, accountability, conflict of interest, donations, oversight, election expenses

УДИРТГАЛ ХЭСЭГ:

Аливаа ардчилсан нийгмийн гол шинжүүдийн нэг нь төрийн тогтолцоог төлөвшүүлэхдээ чөлөөтэй бөгөөд шударга сонгуулийн тогтолцоог бий болгож хэрэгжүүлэх явдал билээ. Энэхүү сонгуулийн үйл явц шударга байх нь ардчиллын үндсэн тулгуур үзэл баримтлалын нэг мөн бөгөөд дэлхийн улс орнуудын улс төрийн тогтвортой байдал, иргэдийн улс төрийн оролцоо болон төрийн байгууллагуудын үйл ажиллагаанд шууд нөлөөлдөг стратегийн чухал ач холбогдол бүхий хүчин зүйлсийн нэг юм. Сонгуулийн санхүүжилт ил тод, хариуцлагатай, шударга байж чадвал улс төрийн өрсөлдөөн бодитой, олон нийтийн итгэлийг хүлээсэн байдлаар явагдах нөхцөл бүрддэг.

Сүүлийн жилүүдэд Монгол Улсад сонгуулиас сонгуулийн хооронд зарцуулагдах зардлын хэмжээ тогтмол өсөж, сонгуулийн кампанит ажлын санхүүжилт улс төрийн өрсөлдөөний шийдвэрлэх хүчин зүйл болж хувирах хандлага ажиглагдаж байна. Энэ байдал нь зөвхөн олон нийтийн дунд төдийгүй судлаач, эрдэмтдийн анхаарлыг татсан, ардчиллын чанарт сөргөөр нөлөөлж болзошгүй тулгамдсан асуудлын нэг болоод байна. Иймээс энэхүү судалгааны ажлын хүрээнд сонгуулийн санхүүжилт, ялангуяа сонгуулийн зардал дахь хандивтай холбоотойгоор илэрч буй эрх зүйн болон ёс зүйн зөрчил, дутагдлын шалтгаан, нөхцөлийг гүнзгийрүүлэн судлах шаардлага зүй ёсоор урган гарч байна.

Монгол Улс 1992 онд ардчилсан Үндсэн хуулиа баталснаас хойш Ерөнхийлөгчийн сонгууль 8 удаа, Улсын Их Хурал болон орон нутгийн сонгууль тус бүр 9 удаа зохион байгуулагдсан. Эдгээр сонгуулийн туршид сонгуулийн санхүүжилт, түүний зардлын хэмжээ тасралтгүй өсөж ирсэн нь эрх зүйн зохицуулалт, хяналтын тогтолцооны үр нөлөө, бодит хэрэгжилтийг эргэн харах шаардлагыг бий болгож байна.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд сонгууль, түүнтэй холбогдон гарсан хууль болон түүнтэй холбогдох бусад эрх зүйн баримт бичиг, Улсын Их Хурлын сонгуульд нэр дэвшигчдийн сонгуулийн санхүүжилтийг харьцуулан судалж, нэр дэвшигчдийн ёс зүйн болон бусад төрлийн зөрчил үүсэх шалтгаан, нөхцөлийг тодруулахыг зорьсон. Үүний зэрэгцээ сонгуулийн санхүүжилтийн эрх зүйн зохицуулалт, хяналтын тогтолцооны өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийж, цаашид түүнийг боловсронгуй болгох, практик хэрэгжилтийг хангах, хяналт шалгалтыг үр нөлөөтэй болгох шинэ арга зам, шийдлийг эрэлхийлэхэд судалгааны гол зорилго оршино.

Судалгааны ажлыг баримт бичиг судлах, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, харьцуулалт хийх зэрэг шинжлэх ухааны судалгааны түгээмэл аргуудыг ашиглан боловсруулсан.

ҮНДСЭН ХЭСЭГ:

Тусгаар тогтносон Монгол Улс нь Үндсэн хуультай болоод 101 жил, Ардчилсан Үндсэн хуулиа баталж мөрдөөд 33 жил болж байгаа билээ. 1992 оны Үндсэн хууль нь Монголын нийгэмд ардчилсан засаглалын бат бөх суурийг тавьж өгсөн бөгөөд иргэн төвтэй, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, ардчилсан засаглалыг төлөвшүүлэхэд чиглэсэн суурь баримт бичиг болж, Монголын нийгмийн улс төр, эрх зүйн харилцааны үндсэн чиглэлийг тодорхойлсон.

Энэхүү ардчилсан засаглалын суурь болох сонгуулийн үзэл санааг Монгол Улсын Үндсэн хууль (1992) -ийн 3 дугаар зүйлийн 1-т “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ” хэмээн тусгаж өгсөн байдаг. Энэ заалт нь ардчиллын шууд болон төлөөллийн хэлбэрийг хослуулан хуульчлан баталгаажуулж, ард түмний эрх мэдлийг бодитой хэрэгжүүлэх гол механизм нь сонгууль мөн болохыг баталгаажуулсан.

1990 оны 5 дугаар сарын 10-нд “БНМАУ-ын АИХ-ын депутатуудын сонгуулийн тухай хууль”-ийг баталсан нь манай улсад анхны олон намын оролцоо бүхий ардчилсан сонгууль явуулах эрх зүйн үндсийг бүрдүүлж өгсөн (Д.Лүндээжанцан Ч.Энхбаатар, 2025, хууд. 62). Энэхүү хууль батлагдсанаар Монгол Улс нэг нам давамгайлсан улс төрийн тогтолцооноос татгалзаж, ардчилсан сонгуулийн зарчмыг бодитоор хэрэгжүүлэх боломж бүрдсэн гэж үздэг.

Онолын үүднээс авч үзвэл сонгууль гэдэг нь санал өгөх замаар улс төрийн шийдвэр гаргах үйл явцыг хэлнэ. Ардчилсан нийгэмд сонгууль нь төрийн албан тушаалд ажиллах өөрийн төлөөллийг сонгоход сонгогчдын оролцоог удирдах, нийгмийн зөвшилцлийг бий болгох механизм байдаг (Э.Гэрэлт-Од, 2021). Иймд сонгууль нь төр ба иргэний хоорондын итгэлцлийг бий болгох, төрийн эрх мэдлийг хуульчлах суурь нөхцөл юм.

Монгол Улсын Ардчилсан Үндсэн хуулийн эхийг баригч, нэрт судлаач Б.Чимид багшийн тодорхойлсноор сонгууль бол зайлшгүй, тогтмол, цаг үеэ олсон чөлөөтэй, өрсөлдөөн бөгөөд ард түмэн засгийн эрхэнд шууд оролцож, төлөөлүүлэн хэрэгжүүлэх хууль ёсны гол арга мөн. Тэр нь төр ёсны орчин үеийн загварын бүрэлдэхүүн хэсэг болсон ардчилсан төлөөлөх байгууллагыг төлөвшүүлэх зүй зохистой, хүчтэй хэрэглүүр юм (Б.Чимид, 2025). Энэ утгаараа сонгууль нь орчин үеийн төрт ёсны салшгүй бүрэлдэхүүн хэсэг болох ардчиллыг төлөвшүүлэх хамгийн үр нөлөөтэй, институцийн чадавх бүхий хэрэгсэлд тооцогддог.

Ардчилсан сонгууль нь олон нийтийг хамаарсан, бүх нийтийн шинжтэй байдаг ба сонгуулийн эрх бүхий иргэн¹ ямарваа нэгэн хязгаарлалт, ялгаварлалгүйгээр сонгуульд чөлөөтэй, эрх тэгш оролцох эрхээр хангагдсан байх ёстой. Энэхүү зарчим хангагдсан нөхцөлд л сонгууль ард түмний жинхэнэ хүсэл зоригийг илэрхийлсэн, хууль ёсны бөгөөд шударга институц болж чадна. Иймээс ардчилсан сонгууль нь зөвхөн хууль зүйн зохицуулалтаар бус, түүнийг хэрэгжүүлэх институцийн хараат бус байдал, иргэдийн улс төрийн соёл, оролцооны идэвхтэй байдлаар тодорхойлогддог онцлогтой юм.

Сонгуулийн санхүүжилтийн эрх зүйн зохицуулалт

Олон улсын эрх зүйн зохицуулалт: Олон улсын эрх зүйн баримт бичиг болох 1948 онд НҮБ-аас батлан гаргасан “Хүний эрхийн түгээмэл тунхаглал”-д “Ард

¹ Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн 3.1.8 дугаар зүйлд “сонгуулийн эрх бүхий иргэн” гэж 18 нас хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай Монгол Улсын иргэнийг хэлнэ.

түмний хүсэл зориг бол засгийн эрх мэдлийн үндэс байх ёстой. Энэ хүсэл зориг нь сонгуулийн бүх нийтийн, тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хураах буюу саналаа чөлөөтэй гаргах явдлыг хангахуйц өөр адил чанартай хэлбэрийг ашиглах замаар явуулж байвал зохих тогтмол, хуурамч бус сонгуулиар илрэлээ олно” (Монгол Улсын Олон улсын гэрээ. IV боть, хууд. 7) хэмээн тунхагласан байдаг.

Монгол Улс 1974 онд нэгдэн орсон “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын факт”-д “Сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хурааж, сонгогчид жинхэнэ хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг баталгаажуулсан, жинхэнэ ёсоор тогтмол явагддаг сонгуульд сонгох буюу сонгогдох эрхтэй” (Монгол Улсын Олон улсын гэрээ. IV боть, хууд. 10) гэж заасан байдаг ба “Чөлөөт шударга сонгуулийн шалгуурын тухай” олон улсын парламентын холбооны 1994 оны 154 дүгээр чуулганы тунхаглал зэрэг баримт бичгүүдийг Монгол Улсын Үндсэн хуульд харшлахааргүй бол дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил баримталдаг.

Монгол Улсын эрх зүйн зохицуулалт: Сонгууль, түүний үйл явц, санхүүжилттэй холбоотойгоор Монгол Улсын Үндсэн хууль (1992), Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль (2019), Улс төрийн намын тухай хууль (2023), Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль (2021), Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль (2020) зэрэг хуулиуд Монгол Улсын хэмжээнд хүчин төгөлдөр үйлчилж байна.

Аливаа ардчилсан нийгмийн гол нэг шинж нь төрийн тогтолцоог төлөвшүүлэхдээ чөлөөтэй бөгөөд шударга сонгуулийн тогтолцоог бий болгож хэрэгжүүлэх явдал юм. Үүний үндсэн хуулийн үндэс нь засгийн бүх эрх ард түмний мэдэлд байх, сонгуулийн эрх бүхий иргэд сонгуульд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа үндсэн дээр саналаа нууцаар гаргах замаар оролцож, төрийн эрх барих төлөөлөгчдийн дээд байгууллага болон төрийн тэргүүн Ерөнхийлөгчийг тодорхой хугацаагаар сонгож байгуулах тухай заалтууд юм (Д.Лүндээжанцан Ч.Энхбаатар, 2025, хууд. 194).

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 49-58 дугаар зүйлд сонгуулийн зардал, нэр дэвшигчдэд хандив өгөх, авах журмыг нарийвчлан хуульчилсан. Жишээлбэл, нэр дэвшигч болон нам, эвслийн сонгуулийн зардалд хандив өгч буй иргэн, хуулийн этгээдийн хандивын дээд хэмжээ (иргэн 10 сая төгрөг, хуулийн этгээд 30 сая төгрөг хүртэл), хандив авч болохгүй иргэн, хуулийн этгээд, түүнд тавих хяналтын талаар тодорхой тусгасан байдаг. Мөн сонгуулийн сурталчилгааны санхүүгийн тайланг санал хураалт болох өдрөөс хойш нам, эвсэл 45 хоногт, нэр дэвшигч 30 хоногт багтаан хувийн аудитын хувийн этгээдээр дүгнэлт гаргуулан төрийн аудитын дээд байгууллагад хүргүүлж, тус байгууллага энэхүү тайланг шалгаад 60 хоногийн дотор дүгнэлтээ нийтэд мэдээлэх, нэг сая болон хоёр сая түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, хуулийн этгээдийг нийтэд мэдээлэх зэрэг үүргийг тусгасан байдаг. Эдгээр үндсэн зохицуулалтууд нь сонгуулийн санхүүжилтийг ил тод болгож, зардал, хандивыг бүртгэх, түүнд хяналт тавих нөхцөлийг бүрдүүлдэг.

Авлигын эсрэг хууль (2006)-д төрийн өндөр албан тушаалтан, тэр дундаа Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их хурал, бүх шатны Иргэдийн төлөөлөгчдийн хуралд нэр дэвшигчид хуульд заасан хугацаанд хөрөнгө, орлогын мэдүүлэг гаргах ба Авлигатай тэмцэх газар болон бусад холбогдох байгууллагууд тэдгээр мэдээллийг бүртгэж олон нийтэд ил тод байдлаар мэдээлэх үүргийг тус тус хүлээсэн байдаг. Энэ нь сонгуульд нэр дэвшигчдийн хувийн хөрөнгө оруулалт, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлийг бууруулах, иргэдэд хэн ямар хөрөнгөөр сонгуулийн компанит ажлаа явуулж буйг ил тод мэдэгдэх зорилготой юм.

Сонгуулийн зардал

Өмнөх 9 удаагийн сонгуулийг хэчнээн төгрөгийн зардлаар зохион байгуулж байсныг дараах үзүүлэлтээс харж болно.




График 1. 1992-2024 оны сонгуулийн зардлын хэмжээ

Дээрх үзүүлэлтээс харахад сонгуулиас сонгуулийн хооронд зардлын хэмжээ тогтмол өсөж, 2024 оны сонгуулийн зардал өмнөх оныхтой харьцуулахад 19.5 тэрбумаар өссөн байна. Энэ нь нэг талаараа мөнгөний ханш суларсантай холбоотой боловч сонгуулийн зардлын хэмжээ өсөх нь сонгуулийн тэгш эрхийн зарчим алдагдахад хүргэх эрсдэлтэй бөгөөд сонгуулийн үр дүн мөнгөтэй нэр дэвшигч, улс төрийн нам, эвслийн талд эергээр шийдэгдэх магадлалтай юм.

Сонгуулийн санхүүжилт:

Сүүлийн жилүүдэд сонгууль, түүний санхүүжилт, хандивтай холбоотой хардалт, мэдээ, шуугиан олны анхаарлыг татах болсон. Ард иргэдийн дунд ч сонгуульд нэр дэвшиж сонгогдоно гэдэг бол мөнгөтэй л хүний хийх зүйл, мөнгөтэй л бол шууд сонгогдоно, хандив өгөөд албан тушаалтай болж байна гэх мэт яриа тасралтгүй яригдсаар байгаа билээ. Юуны учир ийм мэдээ, шуугиан гарах болов гэдгийг бодолцож үзэх нь зүйн хэрэг.

Сонгуулийн санхүүжилт гэдэг нь засаг төрөөс сонгуулийг бэлтгэн явуулах, нам, эвсэл, нэр дэвшигчдээс оролцон ажиллах зориулалтаар төсөвлөн хуримтлуулж, хуваарилан зарцуулдаг мөнгөн хөрөнгийн хангалт юм (Б.Чимид, 2025, хууд. 153). Өөрөөр хэлбэл тухайн сонгуулийг мөнгөөр хангах үйл явцыг сонгуулийн санхүүжилт хэмээн нэрийдэж байгаа юм.

Сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, түүнчлэн нэр дэвшигч сонгуулийн мөрийн хөтөлбөрөө сонгогчдод сурталчлах, тайлбарлан таниулах зорилгоор сонгуулийн сурталчилгааны шууд болон шууд бус зардал (2019) гаргахыг сонгуулийн зардал гэнэ. Сонгуулийн зардал нь хандив, намын өөрийн хөрөнгө, нэр дэвшигчийн өөрийн хөрөнгөөс бүрдэнэ. Сонгуулийн хандив /цаашид хандив гэх/-ийн талаар дэлгэрүүлэн авч үзвэл:

Хандив. Сонгуульд өгч буй хандив нь албан тушаал, эрх мэдэл горилсон арга хэрэгсэл биш бөгөөд улс орныхоо засаглалыг бэхжүүлэн хөгжүүлэх, ард түмний амьдралд үзүүлэх үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор хүмүүсийн өгч буй дэмжлэг юм. Үүнийг буруугаар ашиглаж, өөрт давуу тал бий болгох, албан тушаал, эрх мэдэл олж авах гэсэн хүмүүсийн үйлдэл сүүлийн хэд хэдэн сонгуулийн эргэн тойронд харагдаж байгаа нь сонгуулийн үнэт зүйл, зарчимтай зөрчилдөж байна.

Тухайн сонгуулийн хандив нь мөнгөн болон мөнгөн бус хэлбэртэй байх бөгөөд иргэн арван сая төгрөг хүртэл, хуулийн этгээд гучин сая төгрөг хүртэл мөнгөн хандив өгч болно. Өмнөх 2016 он, 2020 он, 2024 оны сонгуулиудад иргэн болон хуулийн этгээдийн өгч болох мөнгөн хандивын хэмжээг харьцуулан авч үзвэл:




График 2. 2016-2020 оны сонгуулийн мөнгөн хандивын хэмжээ

Дээрх үзүүлэлтээс харахад Монгол Улсын Их Хурлын сонгуульд оролцож буй нэр дэвшигчид өгч болох иргэний хандивын хэмжээ 3 саяас 10 сая хүртэл, хуулийн этгээдийн хандивын хэмжээ 15 саяас 30 сая төгрөг хүртэл хэмжээгээр тус тус нэмэгдсэн байна.

Сонгуулийн зардал тогтмол өссөнтэй холбоотойгоор нэр дэвшигчээс мөнгөтэй байхыг шаарддаг болсон учир тухайн нэр дэвшигч хандив өгөх иргэн болон хуулийн этгээд, санхүүжүүлэгчдийн эрэлд гардаг болсон гэхэд хилсдэхгүй. Үүнээс үүдэн сонгуулийн үр дүн аль их мөнгөтэй талд шийдэгдэх, цаашлаад улс төр чинээлэг хүмүүсийн гарт орох зэрэг асуудлууд үүсэж эхэлдэг.

Энэ нь сонгуулийн үр дүн их хэмжээний санхүүгийн нөөцтэй талд ашигтайгаар шийдэгдэх, улмаар улс төрийн эрх мэдэл эдийн засгийн нөлөө бүхий цөөн бүлэг, баян хүмүүсийн гарт төвлөрөх аюулыг бий болгодог. Өөрөөр хэлбэл, сонгуулийн ардчилсан зарчим алдагдаж, тэгш өрсөлдөөний орчин хумигдаж, мөнгөнөөс хамааралтай улс төрийн орчин нөхцөл бүрддэг. Энэ нь ардчилсан засаглалын суурь үнэт зүйл болох олон нийтийн төлөөлөл, иргэдийн эрх тэгш оролцоог бодитой сулруулах сөрөг үр дагавартай.

Нөгөө талаас, нэр дэвшигчид санхүүжүүлэгч татах явцдаа сонгуульд ялсны дараа тухайн иргэн, хуулийн этгээдийн ашиг сонирхлыг хангах, тодорхой шийдвэр гаргах, бодлогын давуу байдал олгох, албан тушаал, гэрээ хэлцэл, тендер, лиценз зэрэгт давуу эрх олгох амлалт өгөх явдал нь эрсдэлийг дагуулж байдаг. Ийм төрлийн амлалт нь шууд болон шууд бус хэлбэртэй байж болох бөгөөд сонгуулийн дараах төрийн шийдвэр гаргалтад хувийн ашиг сонирхол бий болох, авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх суурь нөхцөлийг бүрдүүлдэг. Улмаар сонгуулийн санхүүжилт нь төрийн бодлогыг худалдаж авах хэрэгсэл болон хувирах аюултай.

Сонгуулийн санхүүжилтийн зохицуулалтад хандивыг мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр олгож болохоор хуульчилсан байдаг. Тухайлбал, мөнгөн бус хандив нь үл хөдлөх болон хөдлөх эд хөрөнгийг ашиглуулах, эзэмшүүлэх, түүнчлэн тодорхой төрлийн үйлчилгээ үзүүлэх хэлбэртэй байж болох талаар эрх зүйн баримт

бичгүүдэд тусгасан байна. Гэвч практик хэрэглээнд эдгээр мөнгөн бус хандивын үнэлгээ, бүртгэл, тайлан, хяналтын тогтолцоо сул байх тохиолдол түгээмэл ажиглагддаг бөгөөд энэ нь далд санхүүжилт, зардлаа нуух, хуульд заасан хандивын дээд хэмжээг тойрон гарах боломжийг бий болгодог.

Сонгуулийн зардал дахь хандивтай холбоотой ёс зүйн зөрчлүүд:

Монгол Улсын хувьд сонгуулийн зардал нэмэгдэхийн хэрээр ёс зүйн шинжтэй болон хууль зөрчсөн үйлдлүүд хэд хэдэн сонгуулийн үеэр ажиглагдах болсон. Ёс зүйн зөрчил нь дан ганц хуль зөрчсөн үйлдэл байх албагүй бөгөөд ардчиллын үнэт зүйл, тэгш, шударга өрсөлдөөн болон олон нийтийн итгэлд харшлах үйлдлүүдийг хэлдэг. Тэгвэл сонгуулийн хандивтай холбоотой илэрч буй ёс зүйн зөрчлүүдийг авч үзье.

1. Хуулиар хориглосон эх үүсвэрээс хандив авах

Сонгуулийн хүрээнд тус зөрчил нь түгээмэл илэрдэг. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэр дэвшигч нь гадаадын иргэн, гадаад улс буюу гадаадын байгууллага, олон улсын байгууллага, гадаадын хөрөнгө оруулалттай байгууллага, төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит компаниудаас хандив авахыг хатуу хориглосон байдаг. Гэсэн хэдий ч эдгээр хязгаарлалтыг зөрчсөн үйлдлүүд практикт ажиглагдаж байна.

Кейс 1. 2024 оны УИХ-ын сонгуульд нэр дэвшигч хандив өгөхийг хориглосон этгээдээс 30.0 сая төгрөгийн хандив авч зарцуулсан нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.711 дахь заалттай нийцээгүй (Үндэсний Аудитын газар, 2024).

Энэхүү тохиолдол нь хууль зүйн хариуцлагаас гадна ёс зүйн хувьд ноцтой зөрчил бөгөөд гол асуудал нь хандивын мөнгөн дүн бус, тухайн хандив нь цаашлаад төрийн бодлого, шийдвэрт нөлөөлөх хүлээлт үүсгэх боломжтой явдал юм. Энэ нь сонгогчдын итгэлийг алдагдуулах, төрийн бодлогын хараат бус байдалд сөргөөр нөлөөлөх зэрэг эрсдэлийг үүсгэж буй хэрэг юм.

2. Гуравдагч этгээдээр дамжуулсан хандив

Энэ нь нэг аж ахуй нэгж эсвэл нөлөө бүхий хүн, хуулийн этгээд олон хүний нэр дээр хандив өгч, сонгуулийн зардал дахь хандивын дээд хэмжээг тойрох маягаар илэрдэг зөрчил бөгөөд нэг төрлийн далд санхүүжилтийн хэлбэр юм.

Кейс 2. Нэг нэр дэвшигчид ижил дүнтэй мөнгөн дүнгээр, нэг өдөр, нэг банкны салбараас олон иргэний нэрээр хандив өгсөн жишээ аудитын 2020 оны тайланд дурдагдсан байдаг.

Энэхүү тохиолдлыг иргэдийн хандив гэж үзсэн байдаг боловч судлаачид үүнийг нэг эх үүсвэрээс гарсан байх магадлал өндөр гэж дүгнэсэн байдаг. Энэ төрлийн зөрчил нь бүрэн нотлох баримттайгаар тогтоогдохгүй тохиолдолд хууль зүйн хариуцлага хүлээлгэхэд хүндрэлтэй боловч ёс зүйн хувьд авч үзвэл сонгуулийн шударга байдалд сөрөг нөлөө үзүүлдэг.

Монгол Улсын Их хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвсэлд нэг сая ба түүнээс дээш хандив өгсөн иргэн, хоёр сая ба түүнээс дээш хандив өгсөн хуулийн этгээдийн жагсаалтаас харахад нийт 635 иргэн, хуулийн этгээд хандив өгсөн байна.




График 3. 1 сая болон 2 сая төгрөгөөс дээш хандив өгсөн иргэн, хуулийн этгээдийн тоо (Үндэсний Аудитын газар, 2024)




График 4. 10 сая болон түүнээс бага хэмжээний хандив өгсөн иргэдийн тоо (Үндэсний Аудитын газар, 2024)

График 3-аас харахад нэг сая болон хоёр сая түүнээс дээш хандив өгсөн нийт 635 иргэн, хуулийн этгээдийг нийтэд мэдээлснээс 509 нь иргэн, 126 нь хуулийн этгээд байна. Нэг сая ба түүнээс дээш хэмжээний хандив өгсөн 509 иргэнээс 421 нь 10 сая төгрөгийн хандив өгсөн байгааг График 4-өөс харж болно.




График 5. 10 сая төгрөгийн хандив өгсөн иргэдийн тоо /нам, эвслээр/

Дээрх 10 сая төгрөг өгсөн иргэдийг аль нам, эвсэлд хандив өгснийг харвал 274 буюу 65% нь Монгол Ардын намд, 95 буюу 22.5% нь Ардчилсан намд, үлдсэн 12.5% нь бусад нам, эвсэлд хандив өгсөн байна.

Эдгээр тоон үзүүлэлтээс харахад нэг намд 10 сая төгрөгийн хандив өгсөн гэж нийтэд мэдээлсэн 274 иргэний хандив нь далд санхүүжилтийн аргаар бий болсон байх магадлалтайг анхаарах хэрэгтэй.

Хандивын ил тод байдлыг хангах үүднээс бүх хандив банкны дансаар шилжиж, шилжүүлэгт хандивлагчийн нэр, регистрийн дугаар, хандивын эх үүсвэрийн мэдээллийг заавал гүйлгээний баримтад тусгадаг. Хэрэв энэ шаардлагыг хангаагүй хандив илэрвэл хүлээн авагч буюу нэр дэвшигч нь буцаан шилжүүлэх үүрэгтэй бөгөөд буцах хаяг тодорхойгүй бол улсын орлого болгох зохицуулалттай. Гэсэн хэдий ч хандив өгч буй иргэн өөрийн нэрийг гүйлгээний утгад бичиж хандив

шилжүүлдэг бөгөөд үүнийг нэр дэвшигч зардлын тайландаа тусгадаг боловч тухайн хандив өгч буй иргэн нь тухайн хэмжээний мөнгөн дүнтэй хандив өгөх санхүүгийн чадамжтай эсэх зэрэгт тавих хяналт сул байгаагаас үүдэн энэ төрлийн ёс зүйн зөрчил нэмэгдэх хандлагатай байна.

3. Улс төрийн нам доторх барьцаа мөнгө

Монгол Улсад тодорхой хугацаанд нам дотор нэр дэвшихийн тулд өндөр хэмжээний барьцаа мөнгө шаардаж ирсэн нь бодит байдал дээр далд хандивын нэг хэлбэр болж байсан. 2008 оноос 2016 онд нам дотор нэр дэвшихийн тулд оролцогчдод тавьсан барьцаа мөнгө огцом өсөж 2012 онд 80 сая, 2016 онд 100 сая төгрөгт хүрсэн тухай судалгаанд дурдсан байдаг (Political Finance in Mongolia, 2018).

Энэ практик нь сонгогдох эрхийн тэгш бус байдал үүсгэж, хуульд заасан хувь хүнээс авах хандивын дээд хэмжээнээс давж зөрчил үүсгэдэг бөгөөд нөгөө талаараа улс төр, төрийн бодлогод нөлөөлөх зорилгоор хуулийн этгээд хандив үзүүлж, түүнийг хувийн нэр дээр бууруулан тайлагнах тохиолдлууд ажиглагдаж ирсэн.

Олон улсын туршлага:

Латви улс: Латви Улс нь улс төрийн намын санхүүжилтэд хатуу хязгаарлалт тогтоож, санхүүгийн ил тод байдлыг хангах зорилготой улс юм. Тус улсын хууль тогтоомжийн дагуу хувь хүнээс ирэх хандив, намын гишүүний татвар, хураамжийн зэрэг нь тухайн намын нийт орлогын 30 хувиас хэтрэхийг хориглосон байдаг. Энэ зохицуулалт нь улс төрийн нам нэг төрлийн санхүүжилтийн эх үүсвэрээс хэт хараат болохоос сэргийлэх, санхүүжилтийг тэнцвэртэй байлгах зорилготой юм.

Мөн нэг иргэнээс нэг намд олгож болох хандивын дээд хэмжээг цалингийн доод хэмжээг 20 дахин үржүүлсэнтэй тэнцэх хэмжээнээс хэтрэхгүй байхаар хуульчилсан нь санхүүгийн нөлөө бүхий этгээд улс төрийн үйл ажиллагаанд нөлөөлөх эрсдэлийг бууруулахад чиглэсэн зохицуулалт бөгөөд төрийн төсвөөс санхүүгийн дэмжлэг авдаг, парламентад суудал бүхий улс төрийн намд олгох хандивын хэмжээг илүү хатуу хязгаарлаж, цалингийн доод хэмжээг 5 дахин үржүүлснээс илүү хандив өгөхийг хориглосон байна. Харин сонгуулиар сонгогчдын 2–5 хувийн санал авсан, төсвийн санхүүжилт авах эрхтэй болсон ч парламентад суудалгүй намуудад олгох хандивын дээд хэмжээг цалингийн доод хэмжээг 12 дахин үржүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр тогтоосон нь улс төрийн өрсөлдөөний тэнцвэрийг хадгалах бодлогын илрэл гэж үзэж болох бөгөөд Латвийн намын санхүүжилтийн зохицуулалтын онцлог нь хандивлагчийн ил тод байдлыг өндөр түвшинд хангадаг байдал юм.

Канад улс: Канад Улс нь улс төрийн нам, нэр дэвшигчдийн сонгуулийн зардлыг ил тод, нарийвчилсан байдлаар тайлагнах эрх зүйн тогтолцоог бүрдүүлсэнээрээ онцлог юм. Тус улсын зохицуулалтаар улс төрийн намууд сонгуулийн зардлын талаарх мэдээллийг Сонгуулийн хороонд заавал хүргүүлэх үүрэгтэй бөгөөд энэ нь нам доторх өрсөлдөөнийг шударга, ил тод явуулах эрх зүйн үндэс болдог.

Сонгуульд оролцохдоо хандив босгосон этгээд зардлын тайлан гаргах үүрэг хүлээдэг бөгөөд нэр дэвшихээр өрсөлдөж буй бүх оролцогч өөрийн сонгуулийн зардлын тайланг холбогдох байгууллагад ирүүлэх ёстой. Нэр дэвшигч нь сонгуулийн үйл ажиллагаа дууссаны дараа дансны үлдэгдлийг харьяалах улс төрийн намдаа шилжүүлэх зохицуулалттай. Харин бие даан нэр дэвшигчийн хувьд зардлын тайлангаа Сонгуулийн хороонд хүргүүлж, үлдэгдэл хөрөнгийг мөн тухайн байгууллагад шилжүүлэхээр хуульчилсан байдаг.

Канадын эрх зүйн зохицуулалтын нэг чухал онцлог нь нэр дэвшигч өөрийн хувийн хөрөнгөөс сонгуулийн зорилгоор зарцуулж болох дээд хэмжээг тогтоож явдал юм. Жишээлбэл, нэр дэвшигч өөрийн хөрөнгөөс 5000 канад доллараас илүү хэмжээний зардал гаргахыг хориглосон нь санхүүгийн чадамжаас үл хамааран нэр дэвшигчдийн хоорондын тэгш өрсөлдөөнийг хангах, мөнгөний нөлөөг улс төрийн үйл явцаас ангид байлгах бодлогын илэрхийлэл юм.

Харин Монгол улсын сонгуульд оролцож буй нэг нэр дэвшигчийн дээд зардлыг тойрог бүрт 895 саяас 1.526 тэрбум төгрөгийн хооронд тогтоосон нь сонгуулийн үйл явц нь мөнгөний нөлөөнд өртөх эрсдлийг нэмэгдүүлж, улмаар тэгш өрсөлдөөний зарчмыг алдагдуулах, ардчиллын чанарт сөргөөр нөлөөлх эрсдэлтэй юм.

Сонгуулийн санхүүжилт, түүний хяналт, сул тал

Сонгуулийн санхүүжилтэд хяналт тавих үндсэн байгууллага нь Сонгуулийн ерөнхий хороо, Үндэсний аудитын газар болон Авлигатай тэмцэх газар юм. Сонгуулийн Ерөнхий хороо нь сонгуулийн зардлын дансыг бүртгэн авч, тайлан мэдүүлгийг хүлээн авах үүрэгтэй бөгөөд зөрчил илэрвэл торгуулийн шийтгэл, дараагийн сонгуульд нэр дэвших эрхийг хасах зэрэг шийдвэр гаргах эрхтэй байгууллага юм. Үндэсний аудитын газар нь нэр дэвшигчийн авсан хандив, зарцуулалт, тайланг шалгасан дүгнэлтийг гаргаж, зөрчил илэрвэл Авлигатай тэмцэх газар болон цагдаагийн байгууллагад шилжүүлэн шалгуулдаг.

Эдгээр байгууллагуудын хяналт нь ихэвчлэн сонгуулийн дараа буюу сонгуулийн тайланд үндэслэн тухайн нөхцөл байдал, цаг хугацаанд хийгддэггүй бөгөөд эдгээр нь ямар нэгэн зөрчил илрэхээс урьдчилан сэргийлэх шинжтэй биш байгаа нь хамгийн том сул тал гэж харж байна. Үүний улмаас хууль зөрчсөн болон ёс зүйн хувьд зөрчилтэй хандив аль хэдийн сонгуулийн үр дүнд нөлөөлсний дараа илрэх тохиолдол түгээмэл тохиолддог.

Монгол улсын хувьд сонгуулийн санхүүжилтийн тогтолцоонд дараах сул талууд илрэн гарч байна. Үүнд:

1. Сонгуулийн санхүүжилтийн ил, тод байдал хангалтгүй байгаа нь сонгуулийн зардал, хандивын талаарх мэдээлэл олон нийтэд бүрэн нээлттэй, ойлгомжтой байдлаар тухайн цаг үедээ хүрч чаддаггүйтэй холбоотой. Сонгуулийн санхүүгийн тайланг ихэвчлэн сонгуулийн дараа нийтэд мэдээлдэг нь сонгогчид тухайн нэр дэвшигч, намын санхүүжилтийн эх үүсвэрийг үнэлэх боломжийг хязгаарлаж, мэдээлэлтэй сонголт хийх зарчмыг алдагдуулдаг. Ил тод байдал хангалтгүй байх нь далд санхүүжилт, гуравдагч этгээдээр дамжуулан нөлөөлөх боломжийг нэмэгдүүлж, улмаар сонгуулийн шударга өрсөлдөөнийг гажуудуулах эрсдэлийг бий болгодог.

2. Хандивын дээд хэмжээ болон түүнд тавигдах шаардлага нь эдийн засгийн нөхцөл байдалтай уялдаагүй байдал ажиглагддаг. Мөн хандив өгч буй иргэн, хуулийн этгээдэд тавих хяналтын тогтолцоо сул байгаа нь далд санхүүжилтийг өөгшүүлэх, улмаар төрийн бодлого боловсруулах түвшинд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг бий болгож байна. Ийм нөхцөлд сонгуулийн санхүүжилт нь бодлогын өрсөлдөөнөөс илүүтэйгээр санхүүгийн чадамжаар өрсөлдөх хэлбэрт шилжих хандлагатай болж, улмаар төрийн бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшинд тодорхой санхүүжүүлэгч хэсэг, бүлгийн нөлөө давамгайлах эрсдэл нэмэгддэг.

3. Ёс зүйн хариуцлага хүлээлгэх тогтолцоо хангалттай бүрдээгүй. Хууль зөрчөөгүй боловч ёс зүйн хувьд ноцтой зөрчилд тооцогдох үйлдлүүдэд хариуцлага хүлээлгэх боломж, нөхцөл өнөөг хүртэл хязгаарлагдмал хэвээр байгаа нь энэ төрлийн зөрчлүүд дахин гарах нөхцөлийг үүсгэж, хуульд нийцсэн боловч ёс зүйн

хувьд зохисгүй үйлдлүүдийг хэвийн мэт ойлгох хандлагыг бий болгож, сонгуулийн шударга байдалд урт хугацааны сөрөг нөлөө үзүүлдэг.

ДҮГНЭЛТ:

Энэхүү судалгааны ажлын хүрээнд Монгол Улсын сонгуулийн санхүүжилт, тэр дундаа Улсын Их Хурлын сонгуулийн зардал, хандивын эрх зүйн зохицуулалт, түүний хэрэгжилт, түүнтэй холбоотой ёс зүйн болон бусад тулгамдсан асуудлуудыг авч үзлээ. Сонгуулийн санхүүжилт нь ардчилсан сонгуулийн шударга, тэгш, ил тод байдалд шууд нөлөөлөх гол хүчин зүйл бөгөөд өнөөгийн нөхцөлд уг тогтолцоо нь ардчиллын чанарыг бэхжүүлэх бус, харин тодорхой хэмжээнд гажуудуулах эрсдэл дагуулж байна.

Монгол Улсад ардчилсан Үндсэн хууль батлагдсанаас хойш сонгуулийн эрх зүйн орчин үе шаттайгаар хөгжиж, сонгуулийн санхүүжилтийг зохицуулах тодорхой механизм бүрдсэн хэдий ч сонгуулийн зардал тасралтгүй өсөх хандлага ажиглагдаж байна. Сонгуулийн зардал өсөхийн хэрээр нэр дэвшигчид, улс төрийн намууд санхүүгийн эх үүсвэртэй илүү ихээр хамааралтай болж, тухайн хандив нь улс төрийн нөлөө, ашиг сонирхлыг хэрэгжүүлэх хэрэгсэл болон хувирах нөхцөлийг бүрдүүлж, цаашлаад сонгуулийн тэгш өрсөлдөөний зарчмыг алдагдуулжээ.

Мөн сонгуулийн санхүүжилтэд хяналт тавих Сонгуулийн Ерөнхий хороо, Үндэсний аудитын газар, Авлигатай тэмцэх газар зэрэг байгууллагуудын хяналт ихэвчлэн сонгуулийн дараа хийгддэг нь аливаа ашиг сонирхлын болон ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх бус, хожимдсон шинжтэй байна.

Иймд Монгол Улсад сонгуулийн санхүүжилтийн тогтолцоог ардчиллыг баталгаажуулах хэрэгсэл болгон хөгжүүлэхийн тулд санхүүжилтийн ил тод байдлыг тухайн цаг үед мэдээлэх нөхцөл, боломжоор хангах, хандивын эх үүсвэрт урьдчилсан болон тасралтгүй хяналт тогтоох, ёс зүйн хариуцлагын бие даасан, үр нөлөөтэй тогтолцоог бий болгох зайлшгүй шаардлагатай байна. Эс бөгөөс сонгуулийн санхүүжилт нь ардчилсан сонгуулийн суурь үнэт зүйлийг сулруулж, улс төрийн эрх мэдэл эдийн засгийн нөлөө бүхий цөөн бүлэгт төвлөрөх сөрөг хандлага цаашид гүнзгийрэх эрсдэлтэй юм.

САНАЛ:

Дээрх дүгнэлтээс үндэслээд сонгуулийн санхүүжилт, түүний зардалтай холбогдох хандивын чиглэлээр өөрийн судалгаандаа үндэслэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Сонгуулийн зардал дахь хандивтай холбоотой мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлэх, хуулийн хэрэгжилтийг хангах

Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 58.1 дүгээр зүйлд сонгуульд оролцож буй нэр дэвшигчид иргэн, хуулийн этгээдийн зүгээс олгогдож буй хандивын хэмжээг нэр дэвшигчид сонгуулийн зардлын тайлангаа Улсын аудитын газар ирүүлснээс 60 хоногийн дотор хянаж, олон нийтэд хандив өгсөн иргэн, хуулийн этгээдийг нийтэд мэдээлэхээр заасныг тухайн цаг үед нээлттэй, ил тод байдлаар мэдээлэх. Ингэснээр олон нийт сонгуулийн хандивтай холбоотой мэдээлэлтэй шуурхай танилцаж, улмаар олон нийтийн хяналтыг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

2. Сонгуулийн үр ашиггүй зардлыг танах байдлаар зардлыг үе шаттайгаар бууруулах

Сонгуулийн үеэр нэр дэвшигчид мөрийн хөтөлбөрөө танилцуулах, сурталчилгаа хийхдээ ухуулагч нарыг ажиллуулдаг. 2024 оны Улсын Их хурлын ээлжит сонгуулийн үеэр 160 гаруй мянган ухуулагч нар ажилласан нь нийт сонгогчдын 10 гаруй хувийг эзэлж байна. Сонгуулийн үеэр ажиллжа буй эдгээр

хүмүүсийн цалин хөлс нь сонгуулийн зардлын тодорхой хувийг эзэлдэг. Иймд сонгуулийн сурталчилгааны урсгалыг зөв тодорхойлох замаар зардлыг бууруулах хэрэгтэй.

Сонгуулийн зардлыг багаар тогтоож, тогтсон хэмжээнд хязгаарлах, аль ч сонгуульд их хэмжээний зардал гаргах боломжгүй болгох нь сонгуультай холбоотой авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлж, нэр дэвшигчид ижил гараанаас тэгш өрсөлдөх боломжийг бий болгох боломтой юм.

3. Хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын хэмжээг нэмэгдүүлэх

“Улс төрийн намын тухай” хууль зөрчигчдөд Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэж байгаа бөгөөд тус хуулиар хориглосон орлого, мөнгөн хандивийн дүнг 2 дахин үржүүлсэнтэй тэнцэх хэмжээний мөнгөн төгрөгөөр торгох эрх зүйн зохицуулалттай. Энэ хариуцлагын арга хэмжээ нь хариуцлагын үр нөлөөг тодорхой хэмжээнд дээшлүүлж байгаа хэдий ч энэхүү эрх зүйн зохицуулалт нь улс төрийн намын санхүүгийн сахилга бат, ил тод байдлыг бүрэн хангахуйц түвшинд хүрсэн гэж дүгнэхэд учир дутагдалтай хэвээр байна. Тодруулбал, хориглосон орлого, хууль бус мөнгөн хандивын хэмжээг хоёр дахин нэмэгдүүлэн торгох нь нэг талаараа зөрчил үйлдэх эдийн засгийн өртгийг өсгөж буй мэт харагдавч бодит практикт зарим улс төрийн нам, томоохон санхүүжүүлэгчдийн хувьд уг торгуулийн хэмжээ нь урьдчилан сэргийлэх шинж чанараа бүрэн хангаж чадахгүй байх эрсдэлтэй.

Иймд Улс төрийн намын тухай хууль болон сонгууль түүнтэй холбогдох хуулиудыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын механизмыг цаашид боловсронгуй болгохдоо торгуулийн хэмжээг зөрчил үйлдэгчийн санхүүгийн чадавх, зөрчлийн давтамж, учруулсан хор уршигтай уялдуулан шаталсан байдлаар тогтоох, мөн торгуулиас гадна төрийн санхүүжилтийг тодорхой хугацаагаар хасах, үйл ажиллагаанд нь хязгаарлалт тогтоох, сонгуульд нэр дэвших эрх олгохгүй байх, нэр дэвших эрхийг тодорхой хугацаагаар хасах зэрэг институцийн шинжтэй нэмэлт арга хэмжээг хавсран хэрэглэх нь зүйтэй бөгөөд зөрчлийн шинж чанар, хор уршгаас хамааран эрүүгийн хариуцлага хүлээлгэх хүртэл хариуцлагын хатуу тогтолцоог бий болгох хэрэгтэй.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Б.Чимид. (2025). Сонгуульд суралцахуй (Тогтолцоо, үйл явц, эрх зүй). Улаанбаатар.
2. Б.Чимид. (2011). Сонгуулийн тогтолцоонд ард түмэн, түүний үндсэн хууль буруутай юу?. Үндсэн хуульт ёсны төлөвшил IV боть
3. Б.Чимид. (2011). Үндсэн хуулийг дээдлэн шүтэх ёс. Улаанбаатар.
4. Б.Чимид. (2017). Үндсэн хуулийн үзэл баримтлал. Улаанбаатар.
5. Б.Чимид. (2008). Төр, нам эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал Улаанбаатар.
6. Д.Лүндээжанцан Ч.Энхбаатар. (2025). Монгол улсын үндсэн хуулийн эрх зүй. Улаанбаатар.
7. Монгол Улсын Олон улсын гэрээ. IV боть. (2015). Улаанбаатар.
8. Үндэсний Аудитын газар. (2024). Монгол Улсын Их хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцсон нам, эвслийн сонгуулийн зардлын тайлан.
9. Э.Гэрэлт-Од. (2021). Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тогтолцооны улс төр, эрх зүйн түүхэн шинжилгээ (1992-2020). Улаанбаатар.
10. Co-funded by the European Union. (2018). Political Finance in Mongolia.

11. <https://shuurhai.mn/p/29475#:~:text=%3E%20%D0%A3%D0%98%D0%A5,%D0>
12. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. Төрийн мэдээлэл эмхэтгэл №01. (1992). Retrieved from Монгол Улсын Үндсэн хууль: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>
13. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. Төрийн мэдээлэл эмхэтгэл №33. (2023). Retrieved from Улс төрийн намын тухай: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16760239349461>
14. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. Төрийн мэдээлэл эмхэтгэл №35. (2006). Retrieved from Авлигын эсрэг хууль: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=8928>
- 15 Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №08. (2020). Retrieved from Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=15125>
16. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №49. (2019). Retrieved from Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=14869>
17. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем. төрийн мэдээлэл эмхэтгэл.№02. (2021). Retrieved from Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=16106891958781>